



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ



Mitigation Action
Facility

Хэрэгжүүлэгч:



Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

“УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ”

Төсөл хэрэгжүүлэх шаардлага

Дэлхийн хамгийн хүйтэн нийслэл Улаанбаатар хотод Монголын хүн амын талаас илүү хувь нь амьдарч байна. Улаанбаатар хотын иргэдийн 20 орчим хувь нь угсармал орон сууцанд амьдарч байгаа нь хотын нийт орон сууцны барилгын 30 хувийг эзэлдэг. Өвлийн улиралд дулаан хангамжийн хүрэлцээгүй байдал, угсармал орон сууцны барилгын дулааны алдагдал өндөр байдгаас үүдэн дотор агаарын хэм стандарт хэмжээнд хүрдэггүй. Үүнээс үүдэн оршин суугчид амьдрахад тав тухгүй, хүйтэн байхаас гадна хөгц мөөгөнцөр үүсэх эрсдэл гарч байна.

Угсармал барилгуудад дулаан техникийн шинэчлэл хийж эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь нэг талдаа оршин суугчдын тав тух, эрүүл амьдрах орчныг бүрдүүлж байгаа бол нөгөө талдаа эрчим хүчний хэмнэлт бий болгосноор хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж буйгаараа ач холбогдолтой. Мөн “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” буюу Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагаанд Монгол Улс манлайлан оролцож, хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувиар бууруулах зорилготой нийцэж байгаа юм.

Дулааны эрчим хүчний үнэ төрөөс өндөр татаастай, хэрэглэгчийн төлж буй төлбөр нь бодит хэрэглээнд бус халаалт авч буй талбайн хэмжээнд үндэслэгдэж байгаа нь барилгын эрчим хүчний хэмнэлтэд үр ашигтай хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарлаж буй юм. Энэ нь Монгол улс нүүрстөрөгч багатай, уур амьсгалд ээлтэй хөгжилд шилжихэд хөрөнгө оруулалт, улс төр, институтын хувьд саад тотгор болж байна

Захиалагч	Хүлэмжийн хийг бууруулах үйл ажиллагааг дэмжих байгууллага Mitigation Action Facility ХБНГУ-ын Холбооны эдийн засаг, уур амьсгалын яам (BMWK) Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Бизнес, эрчим хүчний аюулгүй байдал, нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг (Net-zero) байлгах бодлого хариуцсан газар (DESNZ)
Төсөл хүлээн авагч	Монгол улс
Бодлогын түншлэгч	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (ХББОСЯ)
Хамтрагч байгууллагууд	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (ХББОСЯ), Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (ЗАА), Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ), Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар (ОСНААУГ)
Төсөл хэрэгжих хугацаа	2022-2027

Зорилго

Угсармал орон сууцанд дулаан техникийн шинэчлэл хийх замаар барилгын дулаан алдагдлыг бууруулж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.





Зураг 1: Засвар хийх шаардлагатай угсармал орон сууцны хуучин барилга. Зохиогчийн эрх: GIZ Mongolia

Зураг 2: Дулаан техникийн шинэчлэл хийгдсэн угсармал орон сууцны барилга. Зохиогчийн эрх: GIZ Mongolia

Үр нөлөө буюу ашиг тус

Төсөл нь угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, барилгын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Төслийг Барилга хот байгуулалтын яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (ЗАА) хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагаануудаар барилгын эрчим хүчний хэмнэлтийг дэмжинэ:

- Угсармал орон сууцны барилгын дулаан техникийн шинэчлэлийн санхүүжилтийг урт хугацаанд хангах зорилгоор эрчим хүчний хэмнэлтийн сан байгуулах.

- Улаанбаатар хотын нийт угсармал орон сууцны барилгуудын 30 хувьд дулаан техникийн шинэчлэл хийх.
- Эрчим хүчний хэмнэлтэд хөрөнгө оруулалт хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх.
- Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр хамтран ажиллах байгууллагуудын институтын болон техникийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр мэдээлэл сурталчилгааны ажлыг хийж иргэдийг төсөлд идэвхтэй оролцохыг уриалах.



- ✓ Герман болон Монголын Засгийн Газар хоорондын гэрээ байгуулагдсан.
- ✓ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулсан.
- ✓ Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Эрчим хүчний зохицуулах хороо, ОСНААУГ оролцсон төслийн суурь гэрээ хийгдэв.

Хэвлэлтийг:	Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)	Хамтран хэрэгжүүлэгч:	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
Холбоо барих:	Төслийн удирдагч Ионас Реннер "Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төсөл Нэгдсэн Үндэсний гудамж, Барилга #38, 2-р давхарт, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Улаанбаатар 15160, Монгол Улс Утас: +976-77110515 Цахим хаяг: jonas.renner@giz.de Веб хуудас: www.repare.mn	Захиалагч:	Хүлэмжийн хийг бууруулах үйл ажиллагааг дэмжих байгууллага Mitigation Action Facility ХБНГУ-ын Холбооны эдийн засаг, уур амьсгалын яам (BMWK) Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Бизнес, эрчим хүчний аюулгүй байдал, нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг (Net-zero) байлгах бодлого хариуцсан газар (DESNZ)
Дизайн / Зурагнууд:	Монгол дахь GIZ		
Он, сар:	2025 оны 5 сар		

Нийтлэлийн агуулгыг Монгол дахь GIZ хариуцна.